

АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Ерөнхий зүйл.

Үндэсний аудитын газрын харъяа Архангай аймгийн Аудитын газар нь Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангах үүднээс 2016 оны 1 сарын 06-ны өдөр Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторoor батлуулан ажиллалаа. Нийт 11 зүйлийн 16 ажил хийхээр төлөвлөсөн бөгөөд ажлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

Төлөвлөсөн ажлын биелэлтийн талаар:

Нэг. Авилгын эсрэг соён гэгээрүүлэх, авилгатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- 1. Ажилтнуудад авилгатай тэмцэх хууль тогтоомж, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд авч ҮАГ болон АТГ-т хүргүүлэх.*

Байгууллагын ХОМ хариуцсан ажилтан хуульд заасан хугацаанд Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор, аудитор шинжээч нийт 11 хүний 2015 оны хөрөнгө орлогын мэдүүлгийн гаргуулан авч нэгтэн тайланг ҮАГ болон АТГ-т хугацаанд буюу 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлсэн байна.

Архангай аймгийн Аудитын газарт жирэмсний амралттай байгаа ажилтны оронд түр ажлын байранд орсон ажилтнуудын "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг тухай бүр хүлээн авч ҮАГ-т холбогдох материалын хамт хүргүүлэн, АТГ-аас дүгнэлт гаргуулан ажилласан. 2015 онд 2 мэдүүлэг хянуулж, дүгнэлт гаргуулсаны дараа томилгоо хийгдсэн болно.

Ажилтнуудад Авлигатай тэмцэх хууль тогтоомж, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар зөвлөгөө, мэдээллийг тухай бүр өгч, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд авч, нэгдсэн программд оруулж баталгаажуулан, тайлагнаж ажиллаа.

2. Төрийн аудитын байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах тухай журмын хэрэгжилтийг хангаж ажиллах.

МУЕА-ын баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах журам” болон Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.4 дүгээр зүйлд заасны дагуу Архангай аймгийн Аудитын газрын 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөө гүйцэтгэсэн ажил, одоо хийгдэж байгаа аудитын талаарх мэдээллийг цахим хуудас болон цахим мэдээллийн дэлгэцэнд байршуулсан нь мэдээлэл олон нийтэд ил тод нээлттэй, тодорхой, ойлгомжтой байх нөхцлийг бүрдүүлсэн, олон нийтийн эрх ашигт нийцсэн зохимжтой ажил боллоо.

Мөн аудитын тайланг баталгаажуулснаас хойш нууцын зэрэглэлтэйгээс бусад тайланг тухай бүр цахим хуудаст тогтмол байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж байна. www.audit.mn цахим хуудаст цаг үеийн мэдээллийг тухай бүр шинэчилж байршуулсан байна.

Шалгагдагч байгууллагуудаас шалгалтын явцад болон төгсгөлд ёс зүй, сонирхлын зөрчлөөс сэргийлэх талаар санал асуулга авч байх.

Энэ хүрээнд 2016 онд хийгдсэн нийт аудитын төгсгөлд тухайн аудитад оролцсон аудитын газрын ажилтнуудын ашиг сонирхлын зөрчлийн талаар тухайн аудитын хамрах хүрээнийн үйлчлүүлэгчдээс санал сэтгэгдэл, асуулга авч ажиллалаа. Энэ нь өмнөх жилүүдээс уламжлал болон тогтсон ажил бөгөөд энэ оны тухайд энэ санал асуулгын дүнд тухайн аудитор, шинжээчдийн талаар ёс зүйн зөрчил, дутагдал гаргасан, бусдад ямар нэг ёс зүйгүй сэтгэгдэл төрүүлсэн, харилцааны доголдол гаргасан тохиолдол байхгүй байна.

Энэ санал асуулгын дүнгээс аудитын ажиллагсдын мэргэжлийн ур чадвар, сургалтын хэрэгцээг харах мөн ёс зүйн хэм хэмжээг хэрхэн мөрдөж байгаа зэрэг олон үзүүлэлтийн үр дүнг харах талаас нь илүү ач холбогдол өгч ажилласан. Үүний дүнд нийт 40 санал асуулга авч дүн шинжилгээ хийлээ.

3. Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг цахим хуудсанд хуулийн дагуу тогтмол байршуулж, мэдээллийг шинэчлэх.

Монгол улсын Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9, 10 дугаар зүйл, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.4 дүгээр зүйлд заасны дагуу Архангай аймгийн Аудитын газрын үйл ажиллагаа, төсөвтэй холбоотой нийт 31 мэдээллийг

тогтмол хугацаанд тавихаас 31 мэдээллийг хуулинд заасан хугацаанд нь тавьж ажиллалаа.




Тухайлбал: Байгууллагын хөрөнгө мөнгө зарцуулах болон боловсон хүчинтэй холбогдуулан гаргасан тушаал шийдвэрийг Шилэн дансны тухай хуулийн 6.4.7, 6.4.8 дахь заалтуудын дагуу Шилэн дансны нэгдсэн сайт, байгууллагын нэгдсэн сайт, мэдээллийн цахим дэлгэцээр тухай бүр тогтмол мэдээлж байна.

Үүнээс гадна байгууллага дээр байрлуулсан мэдээллийн цахим самбарт ажиллагсдын дэлгэрэнгүй танилцуулга мэдээлэл холбоо барих утас, гүйцэтгэсэн аудитын дүн, одоо хийгдэж байгаа аудитын зорилт төлөвлөгөө, багийн бүрэлдэхүүн, аудитын хуваарь зэрэг эн тэргүүний мэдээллүүдийг үйлчлүүлэгчдэд ойр байлгах үүднээс тогтмол мэдээлж хэвшлээ.

Хоёр. Авилгын эсрэг хууль тогтоомж, дүрэм журмыг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлэх.

4. Авилгын эсрэг хууль тогтоомж, дүрэм, журмыг цахим хуудас болон мэдээллийн самбарт шинэчлэн байршуулах, иргэд байгууллага чөлөөтэй татаж авах нөхцөлөөр хангах.

Байгууллагын мэргэжлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шинжээч, эрх бүхий албан тушаалтан Б.Азхүү “Албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг”, шинжээч Г.Цог-Эрдэнэ “Авлигын эсрэг хууль, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, авлигаас урьдчилан сэргийлэх тухай” хуулиудын талаар аудитор, шинжээч нарт сургалт явууллаа. Сургалтаар олж авсан мэдлэгийн бататгах, шалгах зорилгоор АХА тэмцээн зохион байгуулсан.



Аймгийн аудитын газрын мэдээллийн самбар, нэгдсэн цахим хуудсанд Авлигатай эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 тогтоол, аймгийн аудитын газрын авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг байршуулан иргэд танилцах, татан авч ашиглах нөхцлийг бүрдүүлсэн.

Гурав. Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах.

5. Аймгийн аудитын газрын 2016 оны жилийн төлөвлөгөөг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах.

Архангай аймгийн Аудитын газрын 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөнөөс эхлэн бусад үйл ажиллагаа, төсөвтэй холбоотой мэдээллийг хуулинд заасан хугацаанд нь тогтмол тавьж ажиллалаа.

Үүнээс гадна байгууллага дээр байрлуулсан мэдээллийн цахим самбарт ажиллагсдын дэлгэрэнгүй танилцуулга мэдээлэл холбоо барих утас, гүйцэтгэсэн аудитын дүн, одоо хийгдэж байгаа аудитын зорилт төлөвлөгөө, багийн бүрэлдэхүүн, аудитын хуваарь зэрэг эн тэргүүний мэдээллүүдийг үйлчлүүлэгчдэд ойр байлгах үүднээс тогтмол мэдээлж хэвшлээ.



6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш нууцын зэрэглэлтэйгээс бусад тайланг тухай бүр цахим хуудаст тогтмол байршуулж байх.

МУЕА-ын баталсан “ Мэдээллийн ил тод байдлыг хангах журам”-ын 2.8-д заасны дагуу гүйцэтгэл гарсан нийт 12 аудитын тайланг цахим хуудсанд тавьсан. Мөн Төрийн аудитын тухай хуулийн 7¹-4-т заасны дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”, “ОНХС-ын хөрөнгийн зарцуулалт”, “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт”, “Засгийн газрын тусгай сан”, “Улсын төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”, “Нэгдсэн төсвийн гүйцэтгэл”, “Улсын нөөцийн 2015 оны бүрдүүлэлт, зарцуулалтын байдал”, “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн зарцуулалт, ашиглалтын байдал”, “2016 оны сонгуулийн зардлын зарцуулалт үр дүн”, “Ойжуулалт, ойн цэвэрлэгээ, үржүүлэх ажиллагааны хөрөнгийн зарцуулалт, үр дүн”, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016 оны 3 дугаар улирлын байдлаарх хөрөнгийн зарцуулалт”-ын байдалд хийсэн аудитын тайлангуудыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан.

Мөн аудитын дүн, илрүүлэлтэд дүн шинжилгээ хийх, ил тод болгох зорилгоор ММНБИ-ийн Архангай салбарын нийт МНБ-дыг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж аудитын явцад илэрч байгаа алдаа, зөрчил түүний шалтгаан, үр дагаварын талаар ил далангүй хэлэлцсэн ба нягтлан бодогчдийн санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулахад ахиц дэвшил гарсан үр дүнтэй ажил болсон бөгөөд нөгөө талаараа аудитын дүнг нийтэд ил тод мэдээлж, хүргэж чадсан үр дүнтэй ажил болсон.

Дөрөв. Байгууллагын төсвийн талаарх гүйцэтгэл, хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх.

7. 2017 оны төсөв, 2016 оны төсвийн гүйцэтгэл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг Шилэн дансны цахим хуудаст байршуулах мөн ил тодын самбарт байршуулах.

Аймгийн Аудитын газрын 2016 оны төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайлан гараагүй байгаа бөгөөд 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Мэдээлэл аудит” ХХК-аар дүгнэлт гаргуулахаар гэрээ байгуулагдаж тухай бүр нь дүгнэлтийг

байршуулсан. Харин энэ тайлангийн хугацааны санхүүгийн тайлангийн аудитын дүнг цаг хугацааны дагуу гүйцэтгэл гарсан тухай бүр мэдээллийг бүрэн эхээр нь Шилэн дансны цахим хуудас, мэдээллийн ил тодын самбарт байршуулах болно.

Тав. Чиг үүргийн дагуу олгож байгаа зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажилагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах.

8. *Санхүүгийн аудитыг гэрээгээр гүйцэтгүүлэх, аудит хийх байгууллагын нэр тусгай зөвшөөрлийн дугаар, гүйцэтгэх ажлын жагсаалтыг цахим хуудсанд байршуулах.*

2016 оны тухайд улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдал, төсвийн хэмнэлтийн горимд шилжсэн, тэвчиж болох зардлыг гаргахгүй байх шаардлага тавигдаж байгаа өнөөгийн нөхцөлд санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгүүлэхээс татгалзаж аль болох өөрсдийн хүчээр хийх, завсрын аудитын хамрах хүрээг өргөтгөх, 3-с доошгүй гэрээт ажилтан ажиллуулах зэргээр шийдвэрлэсэн болно.

Зургаа. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах.

9. *Хүний нөөцийн ил тод байдал, сул орон тооны сонгон шалгаруулалтыг олон нийтэд зарлан мэдээлэх.*

Архангай аймгийн Аудитын газарт жирэмсний амралттай байсан нэг ажилтны оронд түр ажлын байрны зарыг вэб сайт, албан фэйсбүүк хаягаараа мэдээллэж ажилласан.

Долоо. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах түүнтэй танилцах боломжоор хангах.

10. *Тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчдын талаар танилцуулах, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг мэдээлэх, худалдан авсан бараа ажил үйлчилгээний тайланг цахим хуудсанд байршуулах.*

Аудитын газар 2016 онд төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөөгүй тул энэ талаар мэдээлэл гараагүй.

Найм. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх.



Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах нөхцөл бүрдүүлэх. Энэ талаарх цахим хуудсанд байршуулж, тогтмол утас ажиллуулах, шуудангаар авах. Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор хийгдсэн аудитын төгсгөлд тухайн

аудитад оролцсон аудитын газрын ажилтнуудын ашиг сонирхлын зөрчлийн талаар тухайн аудитын хамрах хүрээний үйлчлүүлэгчдээс санал сэтгэгдэл, асуулгыг буцах нэр, хаяггүйгээр авч байна. Мөн ажиллагдсын талаарх санал сэтгэгдлийг байгууллагын цахим хуудас болон албан ажлын утсаар тогтмол авч байна. Үүнд байгууллагын болон ажиллагсдын нэр хүндийг хамгаалах зорилгоор элдэв гүтгэлэг, сөрөг эрсдлээс урьдчилан сэргийлэхэд удирдлагын зүгээс онцгой анхаарч байна.

11. Ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулж гарын үсэг зуруулсан байна.

Мэргэжлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа дотоод сургалтаар ТАБ-ын ажилтны ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн ёс дүрмийн талаар хичээлүүд заагдсан. Аудит бүрийн эхэнд нууцын баталгаа, ашиг сонирхлын зөрчилгүй тухай болон ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах тухай мэдэгдэлд аудитор, шинжээч нар гарын үсэг зурж баталгаа гаргаж хэвшсэн бөгөөд Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг зөрсөн зөрчил гаргаагүй болно. Шинээр орсон ажилтнуудад зориулан Төрийн аудитын байгууллагын ажилтны “Ёс зүйн дүрэм”-ийг судлуулан, танилцуулж байна.

Мөн Үндэсний Аудитын газрын ёс зүйн зөвлөлөөс гарсан зөвлөмж болон Төрийн Аудитын байгууллагын албан хаагчдын үйл ажиллагаанд мөрдүүлэх 6 зүйлийн ёс зүйн ерөнхий хэм хэмжээг “Мэдээллийн цаг”-аар нийт албан хаагчдад танилцуулан хамтаа уншин, сонсож цаашид мөрдөж, анхааран хэвшил болгон ажиллахаар тогтлоо.

Ёс. Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангах.

12. Төрийн аудитын байгууллагын чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээг шинэчлэн цахим хуудсанд байршуулах.

Аудитын газар өөрийн цахим хуудсанд байгууллагын чиг үүрэг, эрхлэх асуудлын талаар мөн ажиллагсдын дэлгэрэнгүй мэдээллийг бүрэн эхээр тавьж олон нийтэд танилцуулж байна. Байгууллагын бүтэц орон тоо өөрчлөгдсөн тохиолдолд мэдээллийг нөхөн шинэчилж байна. Мөн үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг нэгтгэн товхимол хэвлэн гаргаж, байгууллагын дотоод сүлжээнд файлаар татан танилцах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

2016 онд аудитын явцад тохиолддог, эрсдэлтэй асуудлуудаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монголын хуульчдын холбоо, монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгчтэй гэрээ байгуулан үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллалаа.

Арав. Иргэдийн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх.

13. Иргэдийн гомдол, өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгөх.

Аймгийн аудитын газарт 2016 онд иргэн, албан тушаалтнаас 3 өргөдөл, гомдол ирсэнээс 3-ыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хүргүүлсэн байна.

Арван нэг. Авилгын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй асуудлаар АТГ-т мэдээлж байх.

14. Аудитын явцад илэрсэн авилгын болон ашиг сонирхлын зөрчилтэй асуудлын талаарх мэдээллийг АТГ-т мэдээлж байх.

Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлж байх хүрээнд, аудитын явцад АТГ-т мэдээлэх хэмжээний зөрчил илрээгүй байна. Харин татвараа нуусан байж болох аж ахуйн нэгжүүдийн орлогын судалгааг аймгийн Татварын хэлтэст шалгуулахаар хүргүүлсэн.

“Авлигагүй хамт олон” аяны 2-р шатны хүрээнд хийгдсэн ажлын талаар:



ҮАГ-аас санаачилсан “Авлигагүй хамт олон” аяны /2016-2017/ хүрээнд аймгийн Аудитын газрын Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг гаргаж хамт олноор хэлэлцэн баталсан.

Манай байгууллага 2015 оны “Авлигагүй хамт олон” аяны нэгдүгээр шатанд амжилттай оролцож МУ-ын Ерөнхий аудиторос өргөмжлөл гардан авсан бөгөөд 2016 оны 2-р шатны аянд амжилтгаа бататгахыг хичээн ажиллалаа.

15.2016 оны төлөвлөгөөний онцлог нь сар бүр нэг ажилтан нэг ажил зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Аянд ажилтнууд маш идэвхитэй оролцож шинэлэг, үр дүнтэй ажлуудыг зохион байгуулсаныг хэлэхэд таатай байна.



Дарга, тэргүүлэх аудитор Д.Уламбаяр – Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд ойлгомжтой асуулт хариултын байдлаар бэлтгэн орон нутгийн “Архангай амьдрал” сонин хэвлүүлэн олон нийтэд танилцууллаа.

Ахлах аудитор Н.Алтантуяа – Авлигаас урьдчилан сэргийлэх үүднээс байгууллагын өрөөнүүдийн хаалганд сэрэмжлүүлэг уриаг хэвлүүлэн наасан байна.



Шинжээч Х.Алтанчимэг – Хүмүүн цогцолбор 2-р сургуулийн ахлах ангиудын дунд “Авлигын эсрэг хууль, тогтоомж болон урьдчилан сэргийлэх, авлигын хор нөлөө” гэсэн сэдвээр сургалт, танилцуулга хийлээ. Сургалтанд 3 бүлгийн 94 сурагчид хамруулж, авлигын эсрэг мэдлэг мэдээллийг өглөө.




Шинжээч Г.Цог-Эрдэнэ – Байгууллагын ажилтнуудад авлигын эсрэг хууль, тогтоомжоор хичээл бэлтгэн, сургалтын дараа шалгалт авлаа.



Шинжээч Ж.Мөнгөншагай, Н.Энхчимэг нар - “Авлигын эсрэг хууль, тогтоомж болон авлигын хор нөлөө”-ний талаар брошур бэлтгэн байгууллага, иргэдэд тараасан байна. Мөн байгууллагын хамт олондоо “Бид авлигагүй хамт олон” гэсэн лого, хамт олны зургийг аяган дээр хэвлүүлэн дурсгал болгон өгөв.



Шинжээч П.Цэцэгдулам – Байгууллагын хамт олны дунд “Бид авлигагүй хамт олон” гэсэн сэдэвт шүлэг, зургийн уралдаан зохион байгууллаа. Уралдаанд нийт 5 баг оролцож шинжээч Ж.Мөнгөншагай, Х.Алтанчимэг нарын баг 1-р байр, Ахлах аудитор Н.Алтантуяа, шинжээч Б.Нямхүү нарын баг 2-р байрт шалгарлаа.



Шинжээч Б.Азхүү - Байгууллагын www.facebook.com/arkhangaiaudit хуудсаар Хөрөнгө орлогын мэдүүлэг бөглөх зааварчилгаа, авлигаас урьдчилан сэргийлэх, хор нөлөөний талаарх танилцуулга, мэдээллийг 1560 иргэнд түгээж ажиллаа.



Цаашид 2017 онд Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлаа үр дүнтэй зохион байгуулахад онцгой анхааран ажиллах болно.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА АРХАНГАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

2016.11.21